

“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэг. Үндсэн үйлдвэрлэл

Адуунчулууны нүүрсний ордод 2015 оны уулын ажлын батлагдсан төлөвлөгөөгөөр нүүрс 500.0 мян.тн олборлохоос 469.5 мян.тн буюу 93.9%, хөрс 1400.0 мян.м³ хуулахаас 928.5 мян.м³ буюу 66.3%-ийн биелэлттэй ажиллалаа.

Үүнээс Чойбалсан хотын дулааны цахилгаан станц болох “ДБЭХС” ТӨХК–д 410.0 мян.тн нүүрс нийлүүлэх төлөвлөгөөг 402.2 мян.тн-р буюу 98.1%-тай, бусад аж ахуйн нэгж, айл өрхөд төлөвлөгөө ёсоор 90 мян.тн нүүрс нийлүүлэхээс 67.3 мян.тн буюу 74.8%-ийн биелэлттэй ажилласан.

Уурхайн хөрс хуулалтын ажил 5-р сарын 03-наас 11-р сарын 23-ны хооронд явагдаж 928.5 мян.м³ хөрс хуулж, 730-р түвшин дээр 320.0 мян.тн нүүрсний нээгдсэн нөөцийг бүрдүүлж ажилласан байна.

Их засвар техник зохион байгуулалтын талаар

Уул тээврийн машин механизмуудад их болон жилийн засваруудыг хийснээс экскаватор ЭКГ-5А маркийн №12273-д рельс ролик хэсэгчилэн, ЭКГ-4.6Б №784-д рельс ролик бүрэн сольсон мөн 13 автосамосвалд их засвар хийснээс гадна 3 автосамосвалын хөдөлгүүрт бүрэн ээлж, 2 автосамосвалын хөдөлгүүрийг сольж тавьсан.

Компанийн сэлбэг материалын хашаанд /төмөр торон/ ашиглахгүй хадгалж байсан шанаганы стэнкны шүдний суурийн зүүн хэсэгтээ 76 см урт цуурч, 0-6 см зайтай ангайсан гэмтэлтэй байсан, ЭКГ-5А экскаваторын шанаганд их засвар хийх ажлыг 2015 оны 9-р сарын 21-ний өдрөөс эхлэн 11-р сарын 5-ны хийж дуусган №10982 экскаваторт тавьж ашиглалтанд оруулсан

Хөрс хуулалтын ажилд экскаваторуудын шанаганы элэгдсэн 150 шүдэнд наплавка тавьж дахин ашиглаж ажилласан.

Байгал орчин

Байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 7.2 га–д, биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 4.9 га талбайд хийж үүндээ 400ш чацарганы мод, 400ш хайлаас, олон наст ургамалын үр 140 кг-г суулгаж ургуулсан. Намар аймаг орон нутгийн байгаль орчны албанд нөхөн сэргээлтийн ажлаа шалгуулан комиссын актаар хүлээлгэн өгсөн.

Байгаль орчныг хамгаалах ажилд нийт 34.7 сая төгрөг зарцуулснаас техникийн нөхөн сэргээлтэд 25.6 сая.төг, биологийн нөхөн сэргээлтэд 9.1 сая төгрөг, байгаль орчны хяналт шинжилгээний ажлын төлбөрт 3.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Усны тухай хуулийн дагуу тус компани БОНХЯамаар усны дүгнэлт гаргуулж аймгийн БОА-тай гэрээ байгуулж мөн “Монгол ус” ТӨҮГазраар

дүгнэлт гаргуулж, Хэрлэн голын сав газрын захиргаанаас зөвшөөрөл авч ажилласан. Уурхайн шүүрлийн ус шавхан зайлуулсны төлбөрт 4.5 сая төгрөгийн төлбөр төлсөн байна.

Хоёр. Компаний хүний нөөц, бүтэц зохион байгуулалтын талаар:

Захирлын 2015 оны 2-р сарын 24-ний өдрийн А/05 тоот тушаалаар удирдлага, бүтэц, орон тоог баталж нийт 62 ажлын байранд давхардсан тоогоор 147 хүний орон тоотойгоор ажилласан.

Шагнал, урамшуулал

Улс, аймаг, орон нутгийн хэмжээнд шагнал урамшуулалд 50 ажилчин, 21 ахмадыг тодорхойлсноос 54 хүн нь шагнагдсан:

- Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол тэмдэг - 1
- Алтан гадас одон – 2
- Хөдөлмөрийн хүндэт медаль – 3
- Тэргүүний уурхайчин цол тэмдэг – 7
- Яамны жуух бичиг – 4
- Аймгийн тэргүүний ажилтан – 6
- Засаг даргын жуух бичиг – 2
- ЭХГУУҮЭХолбооны Хөдөлмөрийн алдар тэмдэг – 1
- Тэргүүний ажилтан тэмдэг – 2
- Тэргүүний мастер тэмдэг – 1

Гурав. ХАБЭА-н талаар


Компани 2015 онд ХАБЭА-н зардалд 84.9 сая.төгрөг зарцуулсан байна.

1. Компанийн аюулгүй ажиллагааны хяналтыг сайжруулах, баримтжуулах зорилгоор уурхайн үндсэн хэсгүүдэд ХАБЭА-н 1, 2-р шатны хяналтын дэвтэрийг нэвтрүүлсэн.

2. Тус уурхайг түшиглэн Дорнод аймгийн “Уул Уурхайн Аврах Алба”-байгуулагдаж аймагт зохион байгуулагдсан “Онцгой Байдлын Ерөнхий Газар “-ын Улсын үзлэгт бэлтгэл ханган оролцоход 1.5 сая төгрөг зарцуулсан.

Энэ жил нийт ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хоёр удаа хамруулан үзлэг, оношлогоо шинжилгээнд 8.3 сая төгрөг зардал гаргасан байна.

Нийт ажиллагсдыг эрүүлжүүлэх өвчлөлийг бууруулах зорилгоор ажлын байранд эмчилгээ сувилгааг хийх, анхны тусламж үзүүлэх болон ариутгал устгал зэрэг ажилд 7.1 сая төгрөг зарцуулжээ.



Дөрөв. Компанийн хөрөнгө, санхүү

Хөрөнгө

Компанийн нийт хөрөнгө тайлант оны эцэст 10029.1 сая төгрөг болж оны эхний үлдэгдлээс 412.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн дүнгийн 38,2 %-ийг эргэлтийн хөрөнгийн дүн, 61.8%-ийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Тайлант оны эцэст компанийн нийт өр төлбөр 690.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна. Энэ нийт өр төлбөрийн 64.4 хувь буюу 445.0 сая төгрөг нь ХААН банкнаас авсан шугамын зээл эзэлж байна. Энэ зээлийн хувьд 2016 оны 01-р сарын 02-нд буцаан бүрэн төлсөн байгаа.

Эзэмшигчдийн өмч

сая.төг

Д.д	Балансын зүйл	2014.12.31	нэмэгдсэн	хорогдсон	2015.12.31
1	Эзэмшигчдийн өмч	9081.5	524.7	267.8	9338.4
	Дүн	9081.5	524.7	267.8	9338.4

Эзэмшигчдийн өмчийн хувьд тайлант хугацаанд 524.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 2014 оны ноогдол ашигт 267.8 сая төгрөг олгосноор тайлант хугацааны эцэст эзэмшигчийн өмчийн дүн 9338.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч байна.

Тайлант онд компани улс орон нутгийн төсөвт татвараар 1024.6 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 390.9 сая төгрөг, нийт 1415.5 сая төгрөг төлсөн байна.

2015 онд аймгийн төсөвт дараах татварыг төлсөн байна. Үүнд: /мян.төг/

Д.д	Татварын төрөл	2013 онд төлсөн татвар	2014 онд төлсөн татвар	2015 онд төлсөн татвар	ДҮН
1	Хувь хүний орлогын албан татвар	146849.9	111400	182194	440443.9
2	Суутгагчийн хувийн татвар 10	28194.1	14000	96254.8	138448.9
3	Тээврийн хэрэгслийн татвар	2529.9	2468.4	2468.4	7466.7
4	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2323.8	3000	32482.1	37805.9
5	Газрын татвар	6975.6	25011.2	17068.4	49055.2

6	Ашигт малтмалын нөөц ашигласны татвар	114203	154456	106400	375059
7	Бууны татвар	12	12	12	
8	Нэмэгдсэн өртгийн албан татвар	342530.5	382881.9	509568.1	1234981
9	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	78251	46300	74293.6	198844.6
10	Ус ашигласны төлбөрт	10355.4	4819	3629.6	18804
11	Агаарын бохирдлын төлбөр	298.9	250	266.6	815.5
	Дүн	732518.1	744599.3	1024637.6	2501755
1	Нийгмийн даатгалын шимтгэл	283028	356686.3	390890.4	1030605
	Бүгд дүн	1015546.1	1101285.6	1415528	3532360

Орлого, зардал

Тайлант хугацаанд нийт 7263.0 сая.төг-ийн орлого орж, 6666.0 сая.төг-ийн зардал гаргаж ажилласан. Өнгөрсөн онтой харьцуулбал орлого 483.9 сая.төг буюу 7%-иар, зардал 625.1 сая.төг буюу 10.3%-иар тус тус өссөн байна. Татвар төлөхийн өмнөх ашиг өнгөрсөн оноос 141.2 сая.төг-р буурсан.

Үзүүлэлт	Х/нэгж	2013	2014	2015
Нийт орлого	сая.төг	5,744.9	6,779.1	7,263.0
Нийт зардал	сая.төг	5,151.7	6,040.9	6,666.0
ТТӨ Ашиг	сая.төг	593.2	738.2	597.0

2015 онд компаний хэмжээнд тавьсан зорилт хэрхэн биелэгдсэн тухай

1. Ажилчдын тарифт цалинг 30 хувиар, ажлын байрны орон тоог тус тус нэмэгдүүлсэн.
2. Хэрлэн сумын ИТХ, тамгын газартай хамтран ажиллах гэрээтэй ажилласан.
3. Барилгын материал тоосго үйлдвэрлэн борлуулсан.
4. Уурхайнхаа 60 жилийн ойг Дорнодчуудтайгаа хамтран тэмдэглэж энэ уурхай түүний газар баялаг Дорнодчуудын эзэмшил нутаг мөн гэдгийг, улмаар улс орон нутгийн хэмжээнд Адуунчулуун уурхай нь Монголын 2 дахь ахмад уурхай гэдгийг нотолсон

Анхаарал тавьсанд баярлалаа